

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БОЛОН ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЕРКИНЖАН.Р

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний алба Криминалистикийн ахлах шинжээч, Цагдаагийн ахлах дэслэгч Шинжлэн магадлах ухааны магистрант

Аннотаци: “Шинжээч” гэж шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг.

“Шүүхийн шинжилгээний мэргэжилтэн” гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий, шинжилгээний байгууллагын ажилтныг.

“Шинжээчийн дүгнэлт” гэж шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд хийсэн шинжилгээний явц, үр дүнг тусгасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг.

“Шинжилгээний магадлагаа” гэж тусгай мэдлэг бүхий мөрдөгч ул мөр, эд мөрийн баримт болон хэргийн бусад материалд анхан шатны үзлэг оношилгоо хийж, үр дүнг тусгасан баримт бичгийг.

“Чиг үүрэг” гэж үйл явц нь өөр хоорондоо харилцан уялдаа бүхий төлөвлөлт, зохион байгуулалт, идэвхжүүлэлт, хяналтаас бүрдэх цогц ажилбар.

“Хамтын ажиллагаа” гэж гадны болон дотоодын ямар нэг байгууллага, хүнтэй хамтран хийх хөдөлмөр, нэгдэж ажиллах явдал.

“Шүүхийн шинжилгээ” гэж эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны шийдвэр, мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжинд заасан мэдлэг шаардсан асуудал /шинжлэх ухаан, техник, урлаг, түүх, соёл, нягтлан бодох бүртгэл зураг/-ыг шийдвэрлэхийн тулд шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааны үед¹ бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах болон боловсон хүчний ажиллагааг үечлэн судлахад хандууллаа.

Түлхүүр үгс: шүүх шинжилгээ, криминалистик, шинжээч, шүүхийн шинжилгээний мэргэжилтэн, шинжээч эмч, тусгай мэргэжилтэн, гэмт хэрэг.

Товч агуулга: Хууль сахиулах үйл ажиллагаа гэдэг нь нийгмийн харилцааны сөрөг, гэмт үйл явдалуудын эсрэг чиглэж гэмт явдлуудын эсрэг тэмцэх, шудрага ёсыг тогтоодог хүн төрөлхтөний нийгэмшлийн үе шатад үүссэн нэгэн чухал ажиллагаа юм. Хүн төрөлхтөнд хуулийг сахиулж, зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх ямарч ажиллагаа, тогтолцоо байддаггүй гэж төсөөлвөл хүн хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэж араатан амьтнаас ялгарахгүй болно. Ингэхээр хууль сахиулах үйл ажиллагаа нь хүний нийгэмд ямар чухал хэсэг болох нь харагдаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь гэмт явдлын эсрэг шинжлэх ухааны үүднээс тэмцэх тархи нь юм. Шүүхийн шинжилгээний байгууллага бусад хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах нь бүхийн л хууль сахиулах байгууллагуудад шинжлэх ухаанч байдлыг түгээдэг гэж хэлж болно. Иймээс л хэргийн газрын үзлэгийн чанар нь мөрдөн байцаалтын хэргийн цаашдын хувь заяаг шийднэ гэсэн ойлголт урган гарсан.

¹Шүүхийн шинжилгээний тухай хууль, 6 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Шүүхийн шинжилгээний байгууллага нь бүхий л хууль сахиулах байгууллагатай тодорхой хэмжээнд хамтран ажилладаг боловч биелүүлдэг чиг үүргүүдээс болон практик ажиллагаанаас шалтгаалан цагдаагийн байгууллагатай хамгийн нягт уялдаа холбоотой ажилладаг. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллага, Шүүхийн шинжилгээний байгууллага хоёр нь жилийн 365 хоногийн турш тасралтгүй хамтран, нэг бүрэлдэхүүн болж гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа явуулдаг гэж хэлж болно.

Оршил

Хууль сахиулах үйл ажиллагаа гэдэг нь нийгмийн харилцааны сөрөг, эс үйл явдалуудын эсрэг чиглэж гэмт явдлуудын эсрэг тэмцэх, шудрага ёсыг тогтоодог хүн төрөлхтөний нийгэмшлийн үе шатад үүссэн нэгэн чухал ажиллагаа юм. Хүн төрөлхтөнд хуулийг сахиулж, зөрчсөн этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх ямарч ажиллагаа, тогтолцоо байддаггүй гэж төсөөлвөл хүн хүчтэй нь хүчгүйгээ дээрэлхэж араатан амьтнаас ялгарахгүй болно. Ингэхээр хууль сахиулах үйл ажиллагаа нь хүний нийгэмт ямар чухал хэсэг болох нь харагдаж байна.

Хууль сахиулах үйл ажиллагаа дотор хамтын ажиллагаа их чухал байр суурь эзлэнэ. Хууль сахиулах үйл ажиллагааг улсын төрийн болон төрийн бус байгууллагууд хариуцан явуулдаг. Өөрөөр хэлбэл өөр өөрийн чиг үүрэг бүхий олон байгууллагуудын олон алба хаагчдын хамтын ажиллагааны үр нөлөөнд хууль сахиулах үйл ажиллагаа хэрэгжиж биелдэг. Жишээ нь Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг биелүүлдэг бол Шүүхийн шинжилгээний байгууллага гэмт явдалтай тэмцэхэд нотлох баримт цуглуулах, гэмт үйлдлийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлон тогтоох байдаг.

Иймээс энэ илтгэлийн хүрээнд Шүүхийн шинжилгээний байгууллага нь бусад хууль сахиулах байгууллагатай хэрхэн хамтран ажилладаг, эрхзүйн орчин ямар байдаг, цаашид ямар үр дагавар гарч болзошгүй талаар хөндөхийг хичээлээ.

Нэг. Түүхэн хөгжил

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн 44 дүгээр зүйлд “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүх прокурор болон хууль сахиулах бусад байгууллагатай ажлын нягт уялдаа холбоотой криминалистик, шүүх-эмнэлэг, санхүү нягтлан бодох бүртгэл зэрэг шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хянан үзэж, нэгдсэн зохион байгуулалтад оруулан материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээ авна” гэж заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулсан.

Тус төвд Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэсэн бөгөөд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтыг баталсан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн эмч нарыг нэгтгэн “Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай 270 дугаар тогтоол” гарч, цаашид орон тоо, материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, ажлын шаардлага хангасан контор, лабораторийн байртай

болгох асуудлыг нэн даруй шийдвэрлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон ба Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 67, 68 дугаар тогтоолоор Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний алба тохируулагч агентлагийн статустай ажиллаж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь анх 1928 онд дотоодыг хамгаалах газрын даргын тушаалаар шифрийн нууц тусгай тасагт гэрэл зурагчны орон тоог шинээр бий болгож криминалистикийн тоо бүртгэлийг хөтөлж эхэлсэн бөгөөд 1930 онд анхны шинжилгээг Судар бичгийн хүрээлэнгээс Д.Нацагдорж, Цэвэл Дотоодыг хамгаалах газраас Доноров нар хийж дүгнэлт гаргаж байсан байдаг. Үүнээс хойш 1940 онд Дотоод явдлын яамны сайдын 1940 оны 661 тоот тушаалаар УЦСГ-ын Гүйцэтгэх албаны хэлтэст хээ шинжээчийн орон тоог баталж гэмт хэргийн тоо бүртгэл, хурууны хээ авах, гэмт хэрэгтний гэрэг зураг авах ажлуудыг хийхээр батлагдаснаас хойш 1944, 1958, 1959, 1960, 1974, 1990, 1995, болон 1998 онуудад бүтцийн болон нэршлийн хувь өөрчлөгдөн үйл йжиллагаа нь өргөжин тэлж Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн эмч нарыг нэгтгэн “Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба байгуулах тухай 270 дугаар тогтоол”-р тохируулагч агентлагийн статустай болж 2017 онд түүхт 70 жилийнхаа ойг тэмдэглэн өнгөрүүлсэн түүхтэй.

Хоёр. Шүүх шинжилгээний байгууллага нь бусад хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж буй өнөөгийн байдал

Шүүхийн шинжилгээний байгууллага нь гэмт явдлын эсрэг шинжлэх ухааны үүднээс тэмцэх тархи нь юм. Шүүхийн шинжилгээний байгууллага бусад хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах нь бүхийн л хууль сахиулах байгууллагуудад шинжлэх ухаанч байдлыг түгээдэг гэж хэлж болно. Иймээс л хэргийн газрын үзлэгийн чанар нь мөрдөн байцаалтын хэргийн цаашдын хувь заяаг шийднэ гэсэн ойлголт урган гарсан.

Гэмт хэргийг илрүүлэх чиг үүргийг цаг алдалгүй тухай бүрт нь хэрэгжүүлж, энэхүү үйл ажиллагааг үр дүнтэй, тасралтгүй явуулахын хэргийн газрын үзлэгийг тухай бүрт нь чанарын өндөр түвшинд хийж, төрөл бүрийн ул мөр, эд мөрийн баримтыг стандарт аргачлалын дагуу илрүүлж, бэхжүүлж авах шаардлагатай. Ялангуяа шүүхийн шинжилгээг чанартай, үр ашигтай хийх гол үндэс тулгуур нь хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримтыг журамласан эрх зүйн актын хүрээнд зохих стандарт зааврыг баримталж ажиллах явдал юм.

Тиймээс байгууллагаас дээрхи үйл ажиллагааг зохицуулах хүрээнд тодорхой эрх зүйн актуудыг гаргасан байдаг. Тухайлбал дор дурдсан эрх зүйн актууд нь шүүхийн шинжилгээний байгууллага бусад хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллаж, хамтран үйл ажиллагааг шуурхай явуулах нөхцөл боломжийг бүрдүүлдэг байна. Үүнд:

-2009.12.03-ны өдрийн “Шүүхийн шинжилгээний тухай хууль”;

-2009.02.09-ний өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 73,102 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам”;

-2012.06.13-ны өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 343, Б/249 тоот тушаалаар батлагдсан “Шинжилгээний объектийн дагавар хуудас бичих заавар”;

-2012.06.27-ны өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 385, А/278 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам”;

-2017.02.08-ны өдрийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын А/02 тоот тушаалаар батлагдсан “Хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтыг савлах, битүүмжлэх, хаягжуулах, бүртгэх журам”;

-2018.04.06-ны өдрийн Монгол улсын Ерөнхий прокурорын А/36 тоот тушаалаар батлагдсан “Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам”

-2008.03.03-ны өдрийн Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 129,27 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”;

-2013.09.25-ны өдрийн Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 112/А601 тоот тушаалаар батлагдсан “Хамтран ажиллах журам”;

-2013.11.11-ний өдрийн Тагнуулын ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 02/а/712 тоот тушаалаар батлагдсан “Хамтран ажиллах журам”;

Дээрх эрх зүйн актуудаас үзвэл Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн бусад хууль сахиулах байгууллагуудтай уялдаа холбоотой ажилладаг нь харагдаж байна.

Мөн 2018.03.09-ний өдрийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль сахиулах их сургуулийн захирлын хамтарсан А/01,А/35 тоот тушаалаар батлагдсан “Сургалтын гэрээ” байдаг ба энэ нь хууль сахиулах чиглэлээр тус сургуультай байнгын хамтын ажиллагаатай байдгийг илэрхийлсэн хэрэг юм.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь бүхий л хууль сахиулах байгууллагатай тодорхой хэмжээнд хамтран ажилладаг боловч биелүүлдэг чиг үүргүүдээс болон практик ажиллагаанаас шалтгаалан цагдаагийн байгууллагатай хамгийн нягт уялдаа холбоотой ажилладаг.

2009.02.09-ний өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 73,102 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам”-д цагдаа болон шүүхийн шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг тодорхой зааж өгсөн байдаг ба үүнд:

1.1 Энэ журмын зорилго нь цагдаагийн болон шүүхийн шинжилгээний байгууллагууд гэмт хэрэг илрүүлэх, гэмт этгээдийн үйлдлийг нотлон тогтоох чиглэлээр хэргийн газрын үзлэгийг зохион байгуулж явуулах, хэргийн холбогдолтой ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, хураан авах, тэдгээрт шинжилгээ хийж дүгнэлт, магадалгаа гаргах, гэмт хэрэг илрүүлэхтэй холбогдуулан иргэдийн гарын хээний, галт зэвсгийн хонгио ба хошууны, илрээгүй хэргийн ул мөрний, ДНК-ийн гэх мэт нэгдсэн сан бүрдүүлэх, хадгалах, баяжуулах, ашиглах, харилцан мэдээлэл солилцох чиглэлээр хамтран

ажиллах харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журмыг цагдаа, шүүхийн шинжилгээний бүх шатны нэгж, алба хаагчид дагаж мөрдөнө гэж зааснаас гадна хоёр байгууллагын эрх хүлээх үүргийг тодорхойлон тусгасан байдаг.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 2012 оны 385, а/278-р тушаалд цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журамд:

1.1 Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагаас хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэгийг хамтран хийх, цогцос зөөвөрлөх, түүнд шинжилгээ хийх ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэхтэй холбогдсон ажлын уялдааг сайжруулах, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тасралтгүй шуурхай байдлыг хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллага нь хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэгийг хамтран хийх, цогцос зөөвөрлөх, түүнд шинжилгээ хийхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.3 Энэ журмыг нийслэлийн цагдаагийн газар, мөрдөн байцаах газар, замын цагдаагийн газар, дүүргийн цагдаагийн хэлтэс, төмөр замын цагдаагийн хэлтэс, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн криминалистикийн болон шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэс, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны бүх алба хаагчид дагаж мөрдөх бөгөөд нийт бие бүрэлдэхүүнд таниулах, мөрдөж хэвшүүлэх ажлыг Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар,

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тамгийн хэлтэс зохион байгуулна гэсэн байдаг ба бусад байгууллагуудтай ЭХШШТХ, болон ШШТХ-д /5.1. Шүүхийн шинжилгээ хийх үндэслэл нь шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлт байна/ , мөн бусад хууль журманд зааснаар хамтран ажилладаг.

Дээрх бүгдээс үзэхэд цагдаагийн байгууллага, Шүүхийн шинжилгээний байгууллага нь жилийн 365 хоногийн турш тасралтгүй хамтран, нэг бүрэлдэхүүн болж гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа явуулдаг гэж харж болохоор болно.

Цагдаагийн байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллагуудын хооронд хамтран ажиллах эрхзүйн орчин харьцангуй сайн боловч зарим дутагдалтай талууд бий. Жишээ нь цагдаагийн байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллагуудын хооронд гаргасан хамтран ажиллаж журмууд, эрх зүйн актууд дээр хэргийн газрын үзлэгт хамтран оролцож буй мөрдөгч, шинжээчид нь яг ямар, ямар ажиллагаа хийх, хэрхэн ямар дараалалтай хийх зэрэг асуудлуудын талаар нарийн тусгаагүй ерөнхий дурьдсан, мөн хоёр байгууллагын алба хаагчдын хүлээх үүргийн хэрэгжилт хангалтгүй байдаг зэргээс үүдэн практикт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай нотлох баримт цуглуулдаг хамгийн чухал ажил болох хэргийн газрын үзлэгийн чанар муудаж хэргийн явцад сөргөөр нөлөөлөх талтай байдаг.

Гурав. Шүүхийн шинжилгээний байгууллага цагдаагийн байгууллагатай хамтран ажиллахад анхаарах асуудлууд

Аливаа байгууллагын үнэт зүйл нь тухайн байгууллагын эрхэм зорилгоос гадна үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч алба хаагчид

байдаг. Шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд “шинжээч”, “мэргэжилтэн” нь хамгийн үнэт зүйлс билээ. Иймээс ч шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага хууль сахиулах үйл ажиллагаа явуулахад мөн бусад байгууллагуудтай хамтран ажиллахад шинжээч, мэргэжилтэний эрх зүйн байдал, эрх ашиг, ажиллах таатай нөхцөл зэргийг анхаарч үзэх нь зүйтэй.

Шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд нийт албан хаагчдын эрх зүйн байдал холбогдох эрх зүйн актуудаар зохицуулагдсан байдаг. Харин ажиллах таатай нөхцөл талаас нь авч үзвэл алба хаагчдын үүрэг гүйцэтгэдэг нэгжээс шалтгаалж харилцан адилгүй байдаг. Тухайлбал төв байгууллага нь үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын ажиллах нөхцөл харьцангуй сайн байхад нийслэл, аймгуудад жижүүрийн шинжээчийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын ажиллах нөхцөл тун тааруу байна.

2009.02.09-ний өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 73,102 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам”-ын 4.3-д “Хэргийн газрын үзлэгт оролцох криминалистикийн мэргэжилтэнг нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс, замын цагдаагийн газар дээр 24 цагаар үүрэг гүйцэтгүүлж байх зохион байгуулах” гэж заасан боловч ямар нөхцөлд ажиллах, ямар орчинд үүрэг гүйцэтгэхийг тодорхой заагаагүйгээс болж тухайн үүрэг гүйцэтгэж буй нэгжийн даргын шийдвэр, зохион байгуулалтаас шууд шалтгаалж уг орчин бүрдэх болж байна. Тухайлбал зарим дүүргийн хэлтэст шинжээчид үүрэг гүйцэтгэх өрөө гаргаж өгөөгүйгээс тусгайрлах хаалга ч үгүй, ганц сандал бүхий завсарын өрөөнд жижүүрийн шинжээчид маань үүрэг

гүйцэтгэж байна. Уг нь жижүүр¹ийн алба хаагч нь тогтсон ажлын цагаар ажиллаж, хөдөлмөрийн таатай нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэж байж хөдөлмөрийн чадвар алдалт багасч, хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээх, өөрийн эрүүл мэнддээ анхаарах, сурч боловсрох, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх, ар гэр, амьдарч буй орчныхоо ая тухтай байдлыг сайжруулах зэргээр нийгмийн асуудлаа зохицуулах боломж бүрддэг.

Хөдөлмөрийн таатай нөхцөлд ажиллах хугацаа болон нөхцөл багтдаг. Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын ажиллах хугацааны асуудал ч мөн адил үүрэг гүйцэтгэж буй нэгжээс шалтгаалж харилцан адилгүй байна. Зарим аймгуудад жижүүрийн шинжээчийн үүрэг гүйцэтгэх хоёр алба хаагч байдаг ба нэг нь ээлжийн амралт авахад л үлдсэн нэг нь сар орчим хугацаанд өдөр, шөнө тасралтгүй 24 цагаар үүрэг гүйцэтгэх шаардлагатай болдог. Мөн нийслэлийн шүүхийн шинжилгээний газарт хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу нийт жижүүрийн 68 шинжээч, мэргэжилтэн ажилладаг. Одоогийн байдлаар практикт ажиллаж буй жижүүрийн шинжээч, мэргэжилтнүүдийн нэг хоногт хийж гүйцэтгэх үндсэн ажлын ачаалал харьцангуй их бөгөөд ажлын цаг нь Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг байнга зөрчиж байдаг нь нууц биш болоод удаж байна.

Нэг: Жилийн хугацаанд алба хаагчдын зайлшгүй эдлэх ээлжийн амралт, амаржсаны амралт, богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан алба хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн хугацааг нарийвчлан тогтоож , тухайн жилдээ тасралтгүй ажилласан алба хаагчдын бодит тоог гаргахад 3-5 алба хаагч бүтэн жил

¹ Монгол хэлний их тайлбар толь бичиг, “Ээлжийн журмаар үүрэг гүйцэтгэх хүн”

ажиллаагүй гэсэн тоотой тэнцэх үзүүлэлт дунджаар гарч байгаа нь нэг тасгийн алба хаагчдын нэг жилд хэвийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх хугацаанд дүйцүүлэн бодохоор ээлж хоорондын амралтын хугацаа жилийн турш 72 цаг байх ямар ч боломжгүй байна.

Хоёрт: Хэргийн газрын үзлэгийг чанартай хийхийн тулд тодорхой логик дэс дараалал бүхий үе, шатын дэс дарааллыг чанд баримталж ажиллах хэрэгтэй. Хэрэв үе шатыг алгасаж, дэс дарааллаас гажвал буруу таамаглал дэвшүүлэх, мөр нотлох баримтын шинж чанараа алдах эрсдэлтэй учраас жижүүрийн шинжээч, мэргэжилтнүүдийн нэг хэргийн газрын үзлэгийг тогтсон үе, шатуудыг дамжин ажиллахад ямар хугацаа зарцуулахыг бодитой тооцох зорилгоор 24 цагийн хугацаанд хийж гүйцэтгэсэн нийт ажлын бодит хугацааг судалгааны үр дүнгээс дүгнэхэд жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй шинжээч, мэргэжилтний хоногт оролцсон нийт хэргийн газрын үзлэгт зарцуулсан хугацаа нь тухайн хоногийн хугацаанд дуусгах боломжгүй байдгаас тогтмол илүү цагаар ажиллаж байгаа нь харагдаж байна. Мөн жижүүрийн шинжээч, мэргэжилтэн нь 7 хоногт 2-3 удаа ээлжинд ажилладаг бөгөөд энэ нь Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн 70.1 дэх заалтыг ноцтой зөрчиж байна. Үүнээс гадна жижүүрийн шинжээч, мэргэжилтний нэг жилд ажиллах ажлын цагийг өдөрт 8 цагаар ажилладаг алба хаагчийн нэг жилд ажиллах ажлын цагтай математик статистикийн аргаар харьцуулж үзэхэд жижүүрийн шинжээч, мэргэжилтний ээлж хоорондын амралтын хугацаа 72 цаг байхад өдрийн 8 цагаар ажилладаг алба хаагчийн нэг жилд ажиллах ажлын дундаж цагаас 96 цагаар илүү байна. Энэ хугацааг ажлын өдөрт шилжүүлж тооцвол 12 ажлын өдөр илүү ажиллаж байна гэсэн тооцоо гарч байна. Харин ээлж хоорондын амралтын хугацаа 48 цаг байхад өдрийн 8 цагаар ажилладаг алба хаагчийн нэг жилд ажиллах ажлын

дундаж цагаас 816 цаг буюу 102 ажлын өдөр илүү ажиллаж байна гэсэн тооцоо гарч байна.

Мөн жижүүрийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь 24 цагийн турш бэлэн байдал хангаж ажилладаг гэж үзвэл өдрийн цагаар ажилладаг хүнээс 968 цаг бага унтдаг болох нь судалгаагаар нотлогдож байна. Энэ нь нийт 40 хоног огт унтахгүй гэсэн үг юм.

Гуравдугаарт: Ээлжийн ажил нь хүний хэвийн унтаж амрах цагийн хэмнэлийг алдагдуулдаг онцлогтой бөгөөд хүний унтах, сэрэх биологийн хэмнэлийг өөрчилж улмаар нойрны хямрал үүсэх, осол гэмтэлд өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг болохыг судлаачид тогтоожээ.

Ээлжийн ажил хийж, шөнөөр ажиллах нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэн, ихэнхи өвчний эрсдэлт хүчин зүйл болдог байна. Ялангуяа ээлжийн ажил эрхэлдэг хүмүүс нойргүйдэл, даралт, зүрх судасны өвчинд өртөх магадлал хамгийн их байдаг нь харагдаж байна.

Аймгийн алба хаагчдын дунд явуулсан “Ажлын нөхцөл тодорхойлох судалгаа”-нд оролцсон алба хаагчдын нуруу өвдөх, даралт ихсэх, нойрны хямрал, хоол боловсруулах системийн хямрал гэсэн өвчин, зовиуртай байна гэсэн хариултыг сонгосон байна. Мөн жижүүрийн ажлын онцлог болон Монгол орны цаг уурын онцлогоос хамаарч бөөр өвдөх, цисдит, нойрбулчирхай, нүдөвдөх, толгойөвдөх, нунтаг /гарын мөр илрүүлэх нунтаг/-ийн хар шил зэрэг өвчин, зовиур мэдэрч байсан тухай бичжээ.

Дээрхээс үзэхэд Шүүхийн шинжилгээний байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж бусад хууль сахиулах байгууллагад хүндрэл чирэгдэлгүй шуурхай үйлчилж хамтран ажиллах нь зүйтэй боловч үнэт зүйл болох шинжээч мэргэжилтэний ажиллах нөхцөл, эрх зүйн байдалд зохих анхаарал хандуулах нь

зүйтэй байна.

Дүгнэлт

Шүүхийн шинжилгээний байгууллага нь бусад хууль сахиулах байгууллагуудтай нягт хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байна. Хэдийгээр бусад хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдсэн боловч зарим талаар дутагдалтай байна.

- Үүнд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дугаар хэсэгт “хараат бус байх” үндсэн зарчимтай боловч Нийслэлийн дүүргүүд дэх Шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээчид, Аймаг орон нутаг дахь Шүүхийн шинжилгээний албатуудын криминалистикийн шинжээч мөн шинжээч эмч нар нь гэмт хэргийн газрын үзлэгт цагдаагийн байгууллагын жижүүрийн автомашинтай хамт дуудлага руу хамт явж ажил үүрэг гүйцэтгэдэг нь өөрөө хуулийн шүүх шинжилгээний зарчим зөрчсөн асуудал байна.

- 2009 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 73/102 тоот буюу Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан тушаалын 3.1 Нутаг дэвсгэрийн Шүүхийн шинжилгээний албыг ажлын байртай болтол ажлын болон лабораторийн өрөөг түрээсгүйгээр ашиглуулах гэсэн заалт нь 2022 оны байдлаар шинээр албаны байртай болсон 2 аймаг байдаг бусад аймгууд нь түрээсний байр, үлдсэн хэд нь цагдаагийн байранд, нийслэлийн Баянгол дүүрэг, Сонгино хайрхан дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг, Баянзүрх дүүрэг, Хан уул дүүргүүд дэх Криминалистикийн шинжилгээний хэлтсүүд нь бүгд цагдаагийн газрын хэлтсүүд дотор үйл ажиллагаа явуулж байх жишээтэй энэ нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хараат бус байх, нууцыг хадгалах, шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны

үндэслэлтэй хийх шүүхийн шинжилгээний зарчмийг бүрэн зөрчиж байна.

- Хөдөлмөрийн тухай хуулиар 24 жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн бол 72 цаг амрах эрх зүйн зохицуулалттай боловч аймгийн Шүүхийн шинжилгээний албатуудын жижүүрийн албан хаагч нар 24 цаг ажиллаад 48 цаг амрах зуны саруудад 1 хүн ээлжийн амралттай байх үед 24 цаг ажиллаж 24 цаг амарч байгаа нь тус байгууллагын үнэт зүйл буюу албан хаагч нарын бие эрүүл мэндэд сөрөг нөлөөлж байна.

Санал

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 онд багтаан батлуулах.

Цагдаагийн байгууллага, Шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах 2009 оны тушаалыг 2023 онд шинээр гаргах.

Криминалистикийн шинжээч мэргэжлээр төгссөн албан хаагч нарыг бусад байгууллага буюу Цагдаагийн байгууллага, Онцгой байдлын байгууллага руу шилжүүлэхгүй байх үүднээс эрх зүйн баталгааг хангах сургууль төгссөн болровсон хүчнийг 3 жил тасралгүй ажиллах гэрээ байгуулах, ажиллаагүй тохиолдолд диплом хүчингүйд тооцох.

Эх сурвалжийн жагсаалт

-2009.12.03-ны өдрийн “Шүүхийн шинжилгээний тухай хууль”;

-2009.02.09-ний өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 73,102 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам”;

-2012.06.13-ны өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 343, Б/249 тоот

тушаалаар батлагдсан “Шинжилгээний объектийн дагавар хуудас бичих заавар”;

-2012.06.27-ны өдрийн Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 385, А/278 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам”;

-2017.02.08-ны өдрийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын А/02 тоот тушаалаар батлагдсан “Хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтыг савлах, битүүмжлэх, хаягжуулах, бүртгэх журам”;

-2018.04.06-ны өдрийн Монгол улсын Ерөнхий прокурорын А/36 тоот тушаалаар батлагдсан “Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам”

-2008.03.03-ны өдрийн Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 129,27 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”;

-2013.09.25-ны өдрийн Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 112,а/601 тоот тушаалаар батлагдсан “Хамтран ажиллах журам”;

-2013.11.11-ний өдрийн Тагнуулын ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан 02,а/712 тоот тушаалаар батлагдсан “Хамтран ажиллах журам”;

-Сургалтын материал., Засгийн газрын худалдан авах ажиллагаа., УБ.,

-Болдбаатар З., Засгийн газрын худалдан авах үйл ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудлууд., УБ., 2011